210604	Урсгал засвар	119,496,500.00	119,424,400.00	-4,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>66,432,000.00</b>	<b>45,872,015.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	66,432,000.00	45,872,015.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>725,711,400.00</b>	<b>706,515,044.00</b>	<b>690,030,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	699,612,700.00	697,337,200.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	547,200.00	547,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,462,500.00	326,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	444,600.00	182,136.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	169,200.00	99,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,913,800.00	1,731,000.00	0.00
210807	Газрын төлбөр	20,561,400.00	6,291,808.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>132,940,000.00</b>	<b>116,839,839.00</b>	<b>960,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,503,400.00	92,337,797.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,436,600.00	24,502,042.00	0.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>28,000,000.00</b>	<b>28,000,000.00</b>	<b>0.00</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>28,000,000.00</b>	<b>28,000,000.00</b>	<b>0.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	28,000,000.00	28,000,000.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>240,676,800.00</b>	<b>235,804,817.00</b>	<b>40,957,300.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>40,957,300.00</b>	<b>40,957,300.00</b>	<b>40,957,300.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	40,957,300.00	40,957,300.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>199,719,500.00</b>	<b>194,847,517.00</b>	<b>0.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,843,300.00	41,843,280.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,810,200.00	123,810,200.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,066,000.00	29,194,037.00	0.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>587,254,600.00</b>	<b>565,996,324.00</b>	<b>551,397,624.00</b>
223001	Бусад хөрөнгө	587,254,600.00	565,996,324.00	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>650,000,000.00</b>	<b>328,000,000.00</b>	<b>328,000,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	650,000,000.00	328,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,092,979,200.00</b>	<b>6,403,463,689.74</b>	<b>1,578,422,237.06</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>492,642,100.00</b>	<b>520,642,100.00</b>	<b>-</b>
				<b>4,342,473,997.50</b>

310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	492,642,100.00	520,642,100.00	520,642,100.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,885,563,300.00</b>	<b>5,697,974,541.74</b>	<b>5,751,458,138.56</b>
320001	Орон нутгийн төсвөөс	5,885,563,300.00	5,697,974,541.74	5,751,458,138.56
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>714,773,800.00</b>	<b>184,847,048.00</b>	<b>169,438,096.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	522,313,000.00	184,847,048.00	-19,171,880.80
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	192,460,800.00	0.00	-192,460,800.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	205,993,008.39	205,993,008.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	47,162,827.19	65,348,827.19

## 2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,667,161,248.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,362,516,558.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,339,240,948.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,533,039,541.40</b>
210101	Үндсэн цалин	1,121,189,899.40
210102	Нэмэгдэл	799,642.00
210104	Урамшуулал	411,050,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>189,293,383.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	189,053,854.96
210202	Тэтгэмжийн даатгал	59,882.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,945.61
210204	Ажилгүйдлийн даатгал	11,936.40
210205	Эрүүл мэндийн даатгал	119,764.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,057,968.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,055,035.90
210302	Түлш, халаалт	22,056,688.00
210303	Цэвэр, бохир ус	1,454,245.00
210304	Байрны түрээс	492,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>131,414,333.00</b>
210401	Бичиг хэрэг	21,202,710.00
210402	Тээвэр, шатахуун	38,116,360.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,124,119.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	67,971,144.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>349,196,838.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,567,038.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,629,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,932,320.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,062,000.00
210602	Тавилга	1,330,000.00
210604	Урсгал засвар	41,540,320.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,622,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	13,622,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,788,583.70</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,523,206.70
210803	Даатгалын үйлчилгээ	514,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,452.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00
210807	Газрын төлбөр	1,527,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	43,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,895,980.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,394,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,501,980.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,275,610.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,488,111.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,488,111.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>787,499.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	787,499.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>304,644,690.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>304,644,690.00</b>
223001	Бусад хөрөнгө	150,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	154,644,690.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,678,859,620.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,678,859,620.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	157,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,979,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,102,700.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	2,469,777,420.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>11,698,372.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,698,372.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

### **3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

#### **3.5.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,247.5 сая төгрөг болж, өмнөх оноос 703.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	544.0	1,247.5	703.5
<b>Дүн</b>	<b>544.0</b>	<b>1,247.5</b>	<b>703.5</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 1,247.5 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 1,164.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 45.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 2.1 сая, барьцаа хөрөнгийн данс 20.9 сая, Өрхийн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 11.7 сая, Улаангом тохижилт, үйлчилгээ ОНТҮГ-ын харилцах дансны үлдэгдэл 2.9 сая төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,037.9 сая төгрөг болж 517.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	40.5	0.5	-40.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	455.8	0.0	-455.8
Зээлийн хүүгийн авлага	11.9	35.6	23.7
Байгууллагаас авах авлага	194.0	0.00	-194.0
Хувь хүмүүсээс авах авлага	22.2	3.2	-19.0
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	830.7	998.6	167.9
<b>Дүн</b>	<b>1,555.1</b>	<b>1,037.9</b>	<b>517.2</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 1,034.3 сая, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын авлага 3.3 сая, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын авлага 0.2 сая, сумын Засаг даргын тамгын газрын авлага 0.1 сая төгрөгийн авлагууд тус тус байршиж байна.

### 3.5.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 0.0 сая төгрөг болж 0.04 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Цалингийн урьдчилгаа	0.04	0.0	-0.04
<b>Дүн</b>	<b>0.04</b>	<b>0.0</b>	<b>-0.04</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эцсийн үлдэгдэл 542.7 сая төгрөг болж, 1,817.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Боловсрол, Соёл салбарын байгууллагууд Улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	160.5	1.0	-159.5
Эм боох материал	61.5	51.4	-10.1
Бичиг хэргийн материал	37.6	10.8	-26.8
Аж ахуйн материал	263.5	169.0	-94.5
Сэлбэг хэрэгсэл	1.9	1.5	-0.4
Түлш шатах тослох материал	9.6	0.0	-9.6
Барилгын засварын материал	40.3	24.0	-16.3
Хүнсний материал	27.0	0.0	-27.0
Бусад хангамжийн материал	1,757.9	221.1	-1,536.8
Мал амьтад	0.5	63.9	63.4
<b>Дүн</b>	<b>2,360.3</b>	<b>542.7</b>	<b>1,817.6</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэлд Өрхийн эмнэлгийн 190.1 сая, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 52.1 сая, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5.2 сая, Засаг даргын тамгын газрын 295.3 сая төгрөгийн бараа материалууд байршиж байна.

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 32,469.4 сая төгрөг болж, 38,304.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Боловсрол, Соёл салбарын байгууллагууд Улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж , орон сууц	46,789.1	11,048.7	-35,740.4
Хуримтлагдсан элэгдэл	-5,521.7	-2,464.3	-3,057.4
Авто тээврийн хэрэгсэл	1,249.7	1,271.7	22.0
Хуримтлагдсан элэгдэл	-755.2	-640.6	-114.5
Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,195.4	824.0	-3,371.4
Хуримтлагдсан элэгдэл	-2,686.3	-371.5	-2,314.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,742.9	175.0	-1,567.9
Хуримтлагдсан элэгдэл	-1,024.4	-80.0	-944.4
Зам, гүүрний байгууламж	25,703.0	26,611.6	908.6
Хуримтлагдсан элэгдэл	-7,454.4	-11,926.6	4,472.2
Бусад үндсэн хөрөнгө	3,852.8	3,782.7	-70.1
Хуримтлагдсан элэгдэл	-743.1	-524.8	-218.3
Дуусаагүй барилга, байгууламж	42.4	42.4	0.0
Номын фонд	399.6	1.1	-398.5
Программ хангамж	41.1	10.7	-30.4
Хуримтлагдсан элэгдэл	-29.3	-6.3	-23.0
Бусад биет бус хөрөнгө	4,983.2	4,715.6	-267.6
Хуримтлагдсан элэгдэл	-10.8	0.0	-10.8
<b>Дүн</b>	<b>70,774.1</b>	<b>32,469.4</b>	<b>38,304.7</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн программ 0.7 сая, өрхийн эмнэлгийн 1,067.4 сая, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 5,541.8 сая, Засаг даргын тамгын газрын 25,803.3 сая, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 56.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүд тус тус байршиж байна.

### 3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 116.8 сая төгрөг болж 93.2 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Боловсрол, Соёл салбарын байгууллагууд Улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой өглөг	3.9	2.7	-1.2
Байгууллагад төлөх өглөг	101.0	0.0	-101.0
Хувь хүмүүст төлөх өглөг	0.2	0.1	-0.1
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	11.7	20.8	9.1
<b>Нийт дүн</b>	<b>116.8</b>	<b>23.6</b>	<b>93.2</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022\_оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэлд барьцаа хөрөнгийн дансны 20.8 сая, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 2.7 сая, Засаг даргын тамгын газрын 0.1 сая, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 0.07 сая төгрөгийн өр төлбөр байршиж байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 19,738.5 сая төгрөг болж 39,843.0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Боловсрол, Соёл салбарын байгууллагууд Улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,087.1	1,217.4	-14,869.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	15,535.4	15,535.4	0.0
Хуримтлагдсан үр дүн	36,474.1	17,957.3	-18,516.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,020.3	563.8	-6,456.5
<b>Дүн</b>	<b>75,116.9</b>	<b>35,273.9</b>	<b>39,843.0</b>

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022\_оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 1,164.9 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 45.0 сая, хоршоо хөгжүүлэх сангийн 1,037.1 сая Өрхийн эмнэлгийн 1,269.2 сая, Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ-ын 5,597.5 сая, Засаг даргын тамгын газрын 26,098.6 сая, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 61.6 сая төгрөгийн өмч байршиж байна.

### **3.5.7 Орлогын данс**

Тайлант онд татварын орлого 8,741.0 сая, татварын бус орлого 1,167.4 сая, тусламж санхүүжилтийн орлого 9,263.8 сая, нийт 19,172.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### **3.5.8 Зардлын данс**

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 39.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

#### Улаангом сумын Засаг даргын тамгын газар:

1. Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Багийн Засаг дарга, ЗДТГ-ын 12 мэргэжилтний томилолтын зардалд 4,248.0 мянган төгрөг, замын зардалд 800.0 мянган төгрөг, Тэс суманд ЗДТГ-ын 20 албан хаагчдын томилолтын зардалд 3,840.0 мянган төгрөг, Цагаанхайрхан суманд 3 мэргэжилтний томилолтын зардалд 621.0 мянган төгрөг, ОХУ-ын Тува Красноярскийн хязгаарын Курагино районд эрх бүхүй албан тушаалтан байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан хөтөлбөргүй, албан ёсны гэрээ хэлцэл байхгүй, томилолтын тайлан, илтгэх хуудасгүй 4 албан хаагчийн 2,840.0 мянган төгрөг, нийт 12,349.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгосонд зөрчлийг таслан зогсоохыг албан шаардлага болгосон.
2. Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.3-д “Журмын 2.2-д зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн, шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно”, 3.8-д “Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ”, 8.3-д “Энэ журмын 2.5-д заасан үйл ажиллагаанд тухайн байгууллагын төсвийн эрх захирагч, нягтлан бодогч нар хяналт тавьж ажиллана” гэж заасныг тус тус зөрчин 25,245.0 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүй, няравын дансаар дамжуулан зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

#### Улаангом сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалт “Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх гэж тус тус заасныг зөрчин

1,700,000 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсанд алдаа зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага өгсөн.

2. Улаангом сумын ИТХ-ын гэрээт нягтлан бодогч, нярав нь Улаангом сумын Засаг даргын тамгын газар болон ИТХ-аас түлээ нүүрсний хөнгөлөлтийг давхардуулан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт “12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15.1.3 дахь заалтад “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг тус тус зөрчсөнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Улаангом сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 09/03 дугаар тогтоолд Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 7,927.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 8,933.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.7 хувиар биелүүлсэн байна.

##### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Улаангом сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06/03 дугаар тогтоолоор 7,736.0 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 191.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 7,927.4 сая төгрөгөөр баталсан байна.

##### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,092.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 5,855.7 сая төгрөгийг урсгал зардалд, 587.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 650.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 5,674.4 сая төгрөгийг урсгал зардалд, 566.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 328.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр 5,698.0 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 520.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 184.8 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,568.4 сая төгрөг буюу 92.6%-тай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2,678.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,667.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 9.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 22,344.5 сая төгрөгийн 0.5 хувь буюу 111.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 89.4 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Улаангом сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 5.7 хувиар давж биелснээс аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу хүү, торгуулийн орлогоос 180.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Улаангом сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 1,006.3 сая төгрөгөөр давуулсан байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 156, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### 4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 25 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 27 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж 26 Өөрчлөлтгүй, 1 Хязгаарлалтай санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 39.3 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 3 зөрчил 3 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	2	37.5					1	12.3	1	25.2
2	ИТХ	2	2.1					2	2.1		
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>39.6</b>					<b>3</b>	<b>14.4</b>	<b>1</b>	<b>25.2</b>

#### 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,006.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Улаангом сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 1,006.3 сая төгрөгөөр давж, 105.7 хувийн биелэлттэй гарсан байна. Тухайлбал: Цалин хөлс шагнал урамшууллын орлого 55.2 сая хөрөнгийн орлого 266.9 сая, бууны албан татвар 4.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 16.7 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татвар 136.7 сая, малд ногдуулах албан татвар 18.6 сая, Хог хаягдлын үйлчилгээний төлбөр 97.4 сая, Газрын төлбөр 268.4 сая, нэр заагдаагүй орлого 57.3 сая төгрөгөөр тус тус тасарч, үйл ажиллагааны орлого 1,421.4 сая, хөрөнгө борлуулсны орлого 34.9 сая, улсын тэмдэгтийн хураамж 4.4 сая, ойн нөөц ашигласны төлбөр 4.4 сая, Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 2.5 сая, шууд бус орлого 459.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.	1	1,006.3					1	1,006.3
Дүн								
Нийт дүн	1	1,006.3					1	1,006.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

/С.БАТСАЙХАН/

2023 оны 03 сарын 20-ны өдөр